

Төсөл

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХИ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ, ТОО БҮРТГЭЛ ХӨТӨЛЖ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн талаархи статистикийн мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийн санг хариуцаж байгууллага, түүний үүрэг, мэдээллийн сангаас мэдээлэл солилцохтой холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийн сан нь байгууллага бүрийн гэр бүлийн хүчирхийлэлээс хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх явцдаа олж авч, тоо бүртгэлийн мэдээллийг тусгайлан боловсруулсан сан бүхий програм хангамжтай байна.

Хоёр. Мэдээллийн сан, түүнийг хариуцах байгууллага

2.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 15.1.3-т заасан буюу нийгмийн эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, осол гэмтэл, өвчлөл, шалтгааныг судлах мэдээллийн санг бүрдүүлнэ.

2.2. Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 21.1.1-д заасан дараах мэдээллийн санг бүрдүүлнэ. Үүнд:

- а) түр хамгаалан байрлуулах үйлчилгээний;
- б) сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх үйлчилгээний;
- в) нийгмийн халамжийн үйлчилгээний;
- г) хүүхэд хамгааллын үйлчилгээний.

2.3. Цагдаагийн байгууллага нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25.1.1-д заасан дараах мэдээллийн санг бүрдүүлнэ. Үүнд:

- а) цагдаагийн байгууллагад ирүүлсэн гэр бүлийн хүчирхийллийн талаарх гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн;
- б) хүчирхийлэл үйлдэгчийн;
- в) хохирогчийн;
- г) гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, түүний шийдвэрлэлтийн.

Гурав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, мэдээллийн сан хариуцсан байгууллагын чиг үүрэг

3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь энэ журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1.энэ журмын дагуу холбогдох байгууллагаас ирүүлсэн гэр бүл хүчирхийллийн талаарх тоо бүртгэл, статистик мэдээллийг Гэр бүл хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 12.1.4-т заасны дагуу хагас, бүтэн жил нэгтгэн боловсруулж, хүчирхийллийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хэвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

3.1.2.Хамтарсан баг¹-аас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.2.6 дахь хэсэгт заасан мэдээллээс гадна хүчирхийлэлд өртөж эртэй болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалтын нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх талаарх мэдээллийг хүлээн авч, ажлын чиглэл хүргүүлэх;

3.1.3.энэ журам болон програм хангамжид нэмэлт, өөрчлөлт оруулах шинэчлэн боловсруулах санал гаргах, мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сүлжээний хэвийн ажиллагааг хангахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

3.2.Мэдээллийн сан хариуцсан байгууллагууд энэ журмын хүрээнд дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1.хариуцсан мэдээллийн сангаас гэр бүлийн хүчирхийллийн талаарх тоо бүртгэл, статистик мэдээллээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийг хагас, бүтэн жилээр хангах;

3.2.2.бүртгэгдсэн мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, баялаг хөдөлгөөн хийх, хадгалах;

3.2.3.гэр бүлийн хүчирхийллийн тоо бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх ашиглах журмыг байгууллага тус бүр дотоод журмаараа зохицуулж, хянаж тавих;

3.3.Мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээллийг хувийн зорилгоор ашиглах бусдад ашиглуулах, задруулахыг хориглоно.

Дөрөв.Мэдээлэл солилцох

4.1.Энэ журамд заасан байгууллагууд, хамтарсан баг нь бусад байгууллага болон өөр хоорондоо гэр бүлийн хүчирхийллийн талаархи мэдээллийг солилцоно. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурортой зөвшилцөж бата. “Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам”-ыг баримтална.

---оОо---

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйл